



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

“Албан журмын даатгагчдын холбооны шуурхай”
албаны ажиллах журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албаны ажиллах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам”-ыг батлах тухай Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 378 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.


ДАРГА



З.НАРАНТУЯА

000617

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ
ШУУРХАЙ АЛБАНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ**



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Даатгалын тухай хуулийн 12¹.3. “Холбоо нь дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх алба, сантай байна”, 12¹.3.2. “даатгагч, даатгуулагч, хохирогч, иргэнээс даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авч, даатгалын тохиолдлыг шуурхай үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиг үүрэг бүхий шуурхай алба”-ны бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Холбооны шуурхай алба нь жолоочийн даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дуудлагын ажилтанг ажиллуулах, даатгалын тохиолдлын газар дээр шуурхай очиж үзлэг хийх, тэмдэглэл үйлдэх, даатгалын тохиолдол болсныг баримтжуулах, даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид нөхөн төлбөрийг үнэн зөв, шуурхай олгох боломжийг бүрдүүлж ажиллана.

Хоёр. Шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, тавигдах шаардлага

2.1. Шуурхай алба нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулна.

2.2. Аймаг, нийслэлийн салбар нь тухайн орон нутгийн шуурхай албаны үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.3. Шуурхай алба нь Холбооны бүтцэд байх бөгөөд түүний бүрэлдэхүүн, орон тоо, ажилтнуудад тавигдах шаардлага, шалгуурыг Холбоо тогтооно.

2.4. Шуурхай алба нь ажлын байртай, даатгалын тохиолдлын дуудлагыг хуанлийн бүх хоногт 24 цагийн турш хүлээн авах байнгын ажиллагаатай утастай, даатгалын тохиолдлыг тодорхойлж, баримтжуулахад шаардлага хангасан техник хэрэгсэл, орон тооны ажилтнуудтай, даатгалын тохиолдлын дуудлагад хүрч ажиллах “Шуурхай алба” гэсэн таних тэмдэг бүхий автомашинтай байна.

2.5. Шуурхай албаны ажилтан нь нэр, хувийн дугаар, таних тэмдэг бүхий дүрэмт хувцастай, даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийн тэмдэглэл баталгаажуулах дардастай байна.

2.6. Шуурхай албаны нийт ажилтнууд анхан шатны болон мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.

2.7. Холбооны шуурхай алба нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий даатгалын компанийн шуурхай албыг гэрээгээр төлбөртэй гүйцэтгэж болно.

2.8. Гүйцэтгэх удирдлага шуурхай албаны үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

Гурав. Даатгалын тохиолдлын тухай мэдээлэл хүлээн авах, бүртгэх

3.1. Шуурхай албаны ажилтан даатгалын тохиолдлын дуудлагыг хүлээн авч, мэдээлэл өгсөн цаг хугацаа, мэдээлэгчийн овог нэр, хаяг, утасны дугаар мэдээллийн товч утгыг энэ журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан маягтаар бүртгэж, дараах зөвлөгөөг дуудлага өгсөн этгээдэд өгч, шаардлагатай арга хэмжээг авна. Үүнд:

3.1.1. Тухайн даатгалын тохиолдолд буруутай этгээд нь тодорхойгүй, холбогдогчийн гэм буруутай нь тогтоогдоогүй нөхцөлд замын цагдаагийн байгууллагад заавал мэдэгдэхийг зөвлөх, мөн өөрөө мэдэгдэх;

3.1.2. Замын цагдаа болон шуурхай алба даатгалын тохиолдлын газар дээр үзлэг хийх тохиолдолд тээврийн хэрэгслийг хөдөлгөхгүй байх, даатгалын тохиолдлын газрыг орхиж явахгүй байхыг анхааруулах;

3.1.3. Даатгалын тохиолдлын газарт шуурхай алба очих боломжгүй, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учраагүй үед даатгалын тохиолдолд холбогдсон жолооч нар харилцан тохиролцож гэм бурууг хүлээн зөвшөөрсөн бол даатгалын тохиолдол болсныг нотлох баримт бичиг бүрдүүлэх, даатгалын тохиолдлын тодорхойлолтын майгтыг бөглөх талаар зөвлөгөө өгөх /фото зураг, гэрчтэй бол гэрчээс тодорхойлолт авах гэх мэт/;

3.1.4. Даатгалын тохиолдлыг нотлох, мөн нөхөн төлбөр авахад бүрдүүлэх шаардлагатай баримт материалын талаар зөвлөгөө өгөх;

3.1.5. Шуурхай албаны ажилтан даатгалын тохиолдлын мэдээлэл хүлээн авсан даруйд даатгалын тохиолдлын газарт очих ажилтныг нэн даруй явуулна. Шуурхай албаны ажилтан хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан эсхүл зам тээврийн осол гаргагчид хоорондоо маргалдах нөхцөлд замын цагдаад мэдэгдэхийг зөвлөх, мөн өөрөө мэдэгдэх;

Дөрөв. Даатгалын тохиолдлын газар дээрх үзлэг

4.1. Даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгт даатгалын тохиолдол болсон газрын нэр, зам орчны байдал, цаг хугацаа, даатгалын тохиолдол гаргасан болон бусад оролцогч нарыг бүртгэх, даатгалын тохиолдолд холбогдох бусад баримтуудыг баталгаажуулж авах зэрэг үйл ажиллагааг хамааруулна.

4.2. Шуурхай албаны ажилтан даатгалын тохиолдлын газрын байршлыг сайтар тодорхойлж, даатгалын тохиолдлын үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлэн авч, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн ханган даатгалын тохиолдлын газарт аль болох богино хугацаанд очиж дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

4.2.1. Даатгалын тохиолдлын улмаас хүний биед гэмтэл учирсан бол эмнэлгийн тусламж яаралтай дуудах буюу эмнэлэгт хүргэх арга хэмжээ авах;

4.2.2. Даатгалын тохиолдлын газарт ирмэгц үзлэг хийх үеийн аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн хэсэг газрыг тойруулан хаалт тавих;

4.2.3. Даатгалын тохиолдол гаргасан жолооч, хохирогчийг тодруулах, жолоочийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээг шалгаж, видео бичлэг болон фото зургаар баталгаажуулж авах;

4.2.4. Даатгалын тохиолдлын үед хэн нэгний буруу, зөвийг тодорхойлоход нөхцөл байдал хүндрэлтэй, эргэлзээтэй, маргаантай байх үед ямар нэг дүгнэлт урьдчилж гаргахгүй байх, тэнд байгаа хүмүүстэй эелдэг харилцах;

4.2.5. Шуурхай албаны ажилтан нь энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан маягтын дагуу ослын газар дээрх үзлэгийн тэмдэглэлийг үйлдэж гарын үсэг зурж дардас дарж, мөн даатгалын тохиолдол болсон газар дээрх үзлэгийг онцгой шинж тэмдэгүүд, нөхцөл байдлыг оролцуулан видео эсхүл фото зургаар олон талаас нь харагдахуйц, тээврийн хэрэгслийн улсын дугаарыг оруулан баталгаажуулах;

4.2.6. Даатгалын тохиолдол гаргасан этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мансуурсан, бичиг баримтгүй, насанд хүрээгүй бол түүнийг замын цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

4.2.7. Даатгалын тохиолдол гаргасан жолооч нараас нэмэлтээр тайлбар бичүүлж авч болно.

Тав. Даатгалын тохиолдлын баримт бүрдүүлэх, шилжүүлэх

5.1. Даатгалын тохиолдлын газар дээр дуудлагаар ажилласан шуурхай албаны ажилтан дараах баримтыг бүрдүүлэн жолоочийн даатгалын сан болон холбогдох этгээдэд хүлээлгэж өгнө. Үүнд:

5.1.1. Энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу бүрэн гүйцэд бичиж, баталгаажуулсан үзлэгийн тэмдэглэл болон холбогдох материал;

5.1.2. Даатгалын тохиолдлын газар дээрээс баталгаажуулсан видео бичлэг эсхүл фото зураг /видео бичлэг, цахим файлаар байж болно/;


5.1.3. Шуурхай албаны ажилтан нь бүрдүүлсэн баримт материалыг аймаг орон нутгаас ажлын 2 хоногт багтаан, Улаанбаатар хотод нэн даруй жолоочийн даатгалын сан болон холбогдох этгээдэд шилжүүлнэ;

5.1.4. Эрх бүхий этгээд даатгалын тохиолдлын газарт хийсэн үзлэгийн тэмдэглэл, холбогдох зураг, видео бичлэг, баримт материалыг хянаж, тодруулах шаардлагатай бол шуурхай албаны ажилтан болон холбогдох этгээдээр нэмэлтээр баримт гаргуулж болно.

Зургаа. Хэрэгжилт, хяналт, хариуцлага

6.1. Шуурхай албаны үйл ажиллагааны хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 20-ны, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

6.2. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



**ШУУРХАЙ АЛБАНЫ ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ТАЛААРХ
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**

Дугаар:

.....

(аймаг, хот, дүүрэг)

1	Даатгалын тохиолдол болсон огноо	
	Цаг, минут	
2	Дуудлага хүлээн авсан огноо	
	Цаг, минут	
3	Дуудлага өгсөн хүнийн овог, нэр	
	Холбоо барих утас	
4	Даатгалын тохиолдол болсон газрын байршил	
5	Даатгалын тохиолдол болсон үеийн анхан шатны аман мэдүүлэг	
6	Даатгалын тохиолдол гаргасан жолоочийн автотээврийн хэрэгслийн марк, загвар, улсын дугаар	
7	Даатгалын тохиолдол болсон газраас хөдөлсөн эсэх	
	<input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тийм	
8	Даатгалын тохиолдол гаргасан жолооч нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай эсэх	
	<input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тийм	
		1. _____ (даатгагч) 2. _____ (даатгагч)
9	Даатгалын тохиолдол болсон газарт очих шуурхай албаны ажилтны нэр	

Тусгай тэмдэглэл:

.....


Дуудлага хүлээн авсан:

Шуурхай албаны ажилтан: (.....)
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Хянасан:

Шуурхай алба хариуцсан: (.....)
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын шуурхай албаны ажиллах журам”-ын хоёрдугаар хавсралт



**ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ГАЗАР ДЭЭРХ ШУУРХАЙ
АЛБАНЫ ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ**

20 ... оны ...-р сарын ...-ны өдөр
(аймаг, хот, дүүрэг)

Шуурхай албаны дуудлагын ажилтан би
..... нарыг
байлцуулж аймаг,
хотын сум, баг, дүүрэг, хорооны нутаг
..... гудамж, замд гарсан даатгалын тохиолдлын дуудлагыг
оны-р сарын-ны өдрийн цаг минутад хүлээн авч, газар дээрх үзлэгийн
оны-р сарын-ны өдрийн цаг минутад хийхэд уг осол
..... хэлбэрээр (онхолдох, мөргөдөх гэх мэт) гарсан байна.
Даатгалын тохиолдолд өртсөн автотээврийн хэрэгслийн тоо:
Даатгалын тохиолдлын улмаас гэтмсэн хүний тоо:
Даатгалын тохиолдлын улмаас нас барсан хүний тоо:

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ

		А тал	Б тал	В тал
Автотээврийн хэрэгслийн марк				
Автотээврийн хэрэгслийн улсын дугаар				
Автотээврийн хэрэгслийн өмчлөгч				
Жолоочийн овог, нэр				
регистрийн дугаар				
Жолооны үнэмлэхийн дугаар				
Жолоочийн хаяг				
Утасны дугаар				
Техникийн байдал				
Осол гарах мөний	Хурд	Жолоочийн тодорхойлолт		
		Гэрчийн тодорхойлолт		
		Тээврийн хэрэгслийн зорчигчийн тоо		

Хохирогчийн эрүүл мэндийн байдлыг тодорхой бичих:

.....
.....
.....

Эд хөрөнгөд учирсан /автомашин/ эвдрэлийн талаар бичих:

.....
.....
.....

Зам, орчны байдал:

(тохирохыг доогуур нь зурах)

Замын төрөл	Замын бартаа	Замын байдал	Замын хэсэг
Асфальт Бетон Сайжруулсан шороон Хайрган Хөрс	Шулуун тэгш: -Уруу -Өгсүүр Налуу, шулуун: -Уруу -Өгсүүр Тахир, тэгш: -Налуу -Уруу -Өгсүүр Эвдрэлтэй Уул, жалга, гол	Хуурай Нойтон Мөстэй Цастай Хальтиргаатай Чийгтэй Шавартай	Уулзвар дээр: -Зохицуулагддаг -Зохицуулагддаггүй -Явган хүний гарцтай Автобусны зогсоол бүхий Төмөр замын гарамтай Гүүр, тунельд Талбай Суурингийн гаднах Суурингийн доторх Хорооллын доторх Нийтийн хэрэгцээний биш зам
Замын нөхцөл	Зорчих хэсэх	Цаг агаар	Үзэгдэх орчин
Нэг чигийн хөдөлгөөнтэй Эерэг хөдөлгөөнтэй Тусгаарлах зурвастай Тусгаарлах зурвасгүй Эгнээний тоо: 1 2 3 4 5 Явган хүний замтай Явган хүний замгүй Хашлагатай Хашлагагүй Хайстай Хайсгүй	Гэрэлтүүлэгтэй Гэрэлтүүлэггүй	Тогтуун Бүрхэг Бороотой Цастай Аадар бороотой Цасан шуургатай Манантай Салхитай	-Чөлөөтэй -Хязгаарлагдмал -Хангалтгүй

Дараах тохиолдлын аль нь болохыг тодорхойлох:

- Даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан
- Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан
- Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус
- Даатгагч дампуурсан
- Даатгалтай (даатгалын компани)
- Бусад.....

Даатгалын тохиолдлын шалтгаан хэлбэр:

(тохирохыг доогуур нь зурах)

Даатгалын тохиолдол болсон шалтгаан	Даатгалын тохиолдол гарсан хэлбэр
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	- ТХ ТХ-тэй урд талаараа мөргөлдсөн
- Уулзвар гарц нэвтрэх журам	- ТХ ТХ-тэй ард талаараа мөргөлдсөн
- Эсрэг урсгалд орсон	- ТХ ТХ-тэй хажуу талаараа мөргөлдсөн
- Ухрах үйлдэл буруу хийсэн	- ТХ-ээр барилга байгууламж, эд зүйл мөргөсөн
- Хурд хэтрүүлсэн	- Онхолдсон
- Гэрэл дохио зөрчсөн	- Явган зорчигч ТХ-ийн урдуур явж байхад мөргөсөн
- Эгнээ байр буруу эзэлсэн	- Явган зорчигч ТХ-ийн зэрэгцээ явж байхад мөргөсөн
- Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	- Явган зорчигч ТХ-ийн зэрэгцээ явж байхад мөргөсөн
- Эргэх үйлдэл буруу хийсэн	- Явган зорчигч зам дээр зогсож, ажиллаж байхад мөргөсөн
- Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	- Бусад
- Зогсоох арга хэмжээ аваагүй буюу буруу авсан	
- Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийсэн	
- Бусад	

Тусгай тэмдэглэл, даатгалын тохиолдлын зураглал:

.....
.....
.....
.....
.....

Газар дээрх үзлэгийг хийж дууссан: цаг..... минут.

Тэмдэглэл үйлдсэн:

Шуурхай албаны ажилтан: (.....)
(тэмдэг) (гарын үсэг)
(гарын үсгийн тайлал)

Танилцсан: (.....)
тайлал) (гарын үсэг) (гарын үсгийн

..... (.....)
(гарын үсэг) (гар